



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭНД ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР
ЭРЭМБЭЛЭГДСЭН, АРД ИРГЭДЭД ҮР ӨГӨӨЖТЭЙ, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТУСГАЖ, ЗАРЦУУЛАЛТЫГ
ИЛ ТОД МЭДЭЭЛЖ БАЙХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

Аудитын сэдэв: Уул уурхайн аж ахуй нэгжүүд нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилт, үр дүн

Аудитын код: ГАА-2025/36-ШТА-ГА

Аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431, Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677, Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371, Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn

2025 он



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/34

Алтай хот

Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1 дүгээр зүйлийн 1.1, 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Уул уурхайн аж ахуйн нэгжүүд нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, шийдвэрийн хэрэгжилтийг заасан хугацаанд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга, шалгагдагч байгууллагын удирдлага нарт тус тус зөвлөсүгэй.

5. Аудитын ажлын баримтыг 30 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (Д.Цэрэнханд)-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Д.Эрдэнэчимэг)-т даалгасугай.


Т.ГҮНЖИДМАА

822501000074

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	4
Хүснэгтийн жагсаалт.....	4
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх.....	5
Аудитын зорилго.....	5
Аудитын хамарсан хүрээ.....	5
Аудитын арга зүй.....	5
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:	5
Аудитын багийн бүрэлдэхүүн.....	6
БҮЛЭГ 1. Сумдад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг байгуулаагүй байна.	8
БҮЛЭГ 2. Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг хийгээгүй, гэрээг загварын дагуу байгуулаагүй байна.	11
БҮЛЭГ 3. Харилцагч талууд нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээнд тусгаагүй хандив, тусламж авч зарцуулсан байна.	14
БҮЛЭГ 4. Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтийг ил тод мэдээлээгүй, хяналт тавих Хамтын ажиллагааны хороог байгуулаагүй байна.	19
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	23

Товчилсон үгийн тайлбар

Товчлол	Тайлал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах ажил

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Ашиглалтын болон хайгуулын лиценз эзэмшигчийн тоо	7
Хүснэгт 2 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээ	11
Хүснэгт 3 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээ	12
Хүснэгт 4 Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан арга хэмжээний хэрэгжилт (сая төг)...	15

Дүрслэл 1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ	7
Дүрслэл 2 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг мэдээллийн санд байршуулсан байдал	10
Дүрслэл 3 Гэрээг дүгнэсэн байдал /тоогоор/.....	14
Дүрслэл 4 Мөнгөн хандив, тусламжийг дансанд төвлөрүүлсэн байдал (сая төгрөг).....	16
Дүрслэл 5 Хандив тусламжаар өгсөн хөрөнгийн бүртгэл /сая төгрөгөөр/	18

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд “Аудитын сэдэв батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны А/107 дугаар тушаал, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилго

Уул уурхайн аж ахуйн нэгжүүд нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, аймаг, сумдын Засаг даргад хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Аудитыг дараах зорилтын хүрээнд хийлээ. Үүнд:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг хууль, журмын дагуу байгуулж, төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг хангуулж ажилласан эсэх;
- Нутгийн захиргааны байгууллага нь нийгмийн хариуцлагын гэрээг холбогдох хууль, журмын дагуу байгуулж, ил тод мэдээлсэн эсэх;
- Харилцагч талууд нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангуулж, холбогдох арга хэмжээ авч ажилласан эсэх;
- Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтийг ил тод мэдээлж, түүнд тавих хяналт үр дүнтэй эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын Засаг дарга, ЗДТГ, ОУИТБС-ын дэд зөвлөл, аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Байгаль орчны газар, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигч, иргэний нийгмийн байгууллага, бусад холбогдох байгууллагуудын 2023-2025 оны тухайн үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000 стандартад нийцүүлэн баталсан дараах стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлалыг ашиглав.

- *Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, тулгуур зарчим”*
- *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”*

Уул уурхайн аж ахуйн нэгжүүд нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан гэрээ, гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт материал, ОУИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагаа, судалгаа, тайланг судалж, дүгнэлт хийх, холбогдох хууль эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Хууль:

- Монгол Улсын Үндсэн хууль

- Ашигт малтмалын тухай хууль
- Төсвийн тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 190 дүгээр тогтоол “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай”
- Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоол “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоол “Гэрээний загвар батлах тухай”
- Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 263 дугаар тогтоол “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай”

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа хянан удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналт хэрэгжүүлж, аудитыг ахлах аудитор Д.Цэрэнханд ахлан, ахлах аудитор М.Атарцэцэг, аудитор Э.Сүнжидмаа, Н.Гэрэлмаа, С.Санчирмаа, Г.Энхдэлгэр, О.Энхтөр, Б.Мөнхболд нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Аудитын хүндрэл бэрхшээл

Аудитаар сумдын Засаг дарга, тусгай зөвшөөрөл эзэмшигч нарт баримт материал ирүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн бөгөөд Бугат, Цогт сум болон Салхит-Алтай ХХК, Цогц эрин транс ХХК, Хан Алтай ресурс ХХК, Зөөлөн ресурс ХХК, Талын шуурга констракшн ХХК, Ар Эм Си бренд ХХК-иуд нотлох баримт, холбогдох мэдээллийг ирүүлээгүй болно.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана” гэж заасан.

Аймгийн хэмжээнд уул уурхайн лиценз эзэмшигч 2024 онд 2-оор, 2025 онд 5-аар нэмэгдэж 2025 оны 09 дүгээр сарын байдлаар хайгуулын 73, ашиглалтын 65, нийт 138 лицензийг 86 аж ахуйн нэгж эзэмшиж байна.


Хүснэгт 1 Ашиглалтын болон хайгуулын лиценз эзэмшигчийн тоо

Он	Ашиглалтын лицензын тоо		Хайгуулын лицензийн тоо	
	Үйл ажиллагаа явуулсан	Үйл ажиллагаа явуулаагүй	Үйл ажиллагаа явуулсан	Хугацаа дууссан
2023 он	14	50	71	53
2024 онд нэмэгдсэн	-	1	1	3
2025 онд нэмэгдсэн	-	-	1	1
Дүн	14	51	73	57

Эх сурвалж://www.eitimongolia.mn/

Засгийн газрын “Олборлох байдлын ил тод санаачилгын тухай” 2010 оны 190 дүгээр тогтоолын 2-т “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гарган, нийтэд мэдээлж, журмын дагуу тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай” гэж заасан.

Дүрслэл 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээ



Говь-Алтай аймгийн хэмжээнд 2009 оноос хойш орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын нийт 64 гэрээ байгуулснаас Ашигт малтмал газрын тосны газрын эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд /www.iltodgereee.mn/ 2023 онд 10, 2025 оны 09 дүгээр сарын байдлаар 10 гэрээг ил тод мэдээлж, 2024 онд мэдээлээгүй байна.

Эх сурвалж: Аудитын тооцоолол

Говь-Алтай аймгийн Засаг даргын 2023 оны А/225 дугаар захирамжаар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Тус зөвлөлийн 2022-2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг www.eitimongolia.mn сайтад мэдээлжээ.

БҮЛЭГ 1. Сумдад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг байгуулаагүй байна.

Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд компанийн төлөөллийг томилоогүй байна.

1.1 Монгол Улсын Засгийн газрын “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 2012 оны 222 дугаар тогтоолын 11.2¹, 11.5²-д заасны дагуу сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг байгуулж, тус зөвлөл нь компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэгтэй.

1.2 Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа сумдад Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг байгуулаагүй байна.

1.3 Аймагт Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг аймгийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/172 дугаар “Дэд зөвлөл байгуулах тухай” захирамжаар анх 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

1.4 Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/172 дугаар захирамжаар уг зөвлөлийг шинэчлэн 10 хүний бүрэлдэхүүнтэй болгосон байна.

1.5 Зөвлөлийн бүрэлдэхүүнд орон нутгийн захиргааны байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн төлөөллийн 3 талын тэгш оролцоог хангаж, үйл ажиллагаанд хяналт тавих зохицуулалттай байна.

1.6 Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийн захиргааны байгууллагын төлөөлөл 8, иргэний нийгмийн төлөөлөл 2-ыг томилж, компанийн төлөөллийг томилоогүй нь Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд дараах албан тушаалтнуудыг томилсон байна. Үүнд:

Төрийн захиргааны байгууллагын төлөөлөл: Аймгийн Засаг даргын орлогч, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн захиргааны хэм хэмжээний акт, гэрээ, сумдын эрх зүйн акт хариуцсан мэргэжилтэн, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хэвлэл мэдээлэл, цахим засаглал, сүлжээний аюулгүй байдлын бодлогын мэргэжилтэн, Байгаль орчин, аялал, жуулчлалын газрын дарга, Татварын хэлтсийн дарга, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн геологи, уул уурхайн хяналтын улсын ахлах байцаагч.

Иргэний нийгмийн төлөөлөл: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Алтайн бичил уурхайчдын эв нэгдлийн холбоо- төрийн бус байгууллагын зохицуулагч

¹ 11.2-т " Компаниуд болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ОУИТБС-ын дэд зөвлөлийг аймаг, нийслэлийн Засаг даргын орлогчоор ахлуулсан орон нутгийн захиргааны байгууллага, компаниуд, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн төлөөллийн 3 талын тэгш оролцоо бүхий бүрэлдэхүүнтэйгээр байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавих",

² 11.5-д "Нутаг дэвсгэрт нь уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа суманд энэ тогтоолын 11.2-т заасан дэд зөвлөлийг сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан байгуулж ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах"

Иймд аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд компанийн төлөөллийг томилох **зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.**

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг байгуулах **зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.**

Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй байна.

1.7 Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл 2023 он, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна.

1.8 Тус зөвлөл нь 2023 онд 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 6 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 2 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна. Харин 2024 онд төлөвлөсөн 7 арга хэмжээнээс 3 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 4 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

1.9 Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаагүй байна.

1.10 Дэд зөвлөл нь 2023-2025 онд хуралдаан зохион байгуулсан гэх боловч нотлох баримтаар дэмжигдэхгүй байгаа нь “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 213, 244 дэх заалтыг хэрэгжүүлээгүй гэж үзэхээр байна.

1.11 Тус зөвлөл нь үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, биелэлтийг тайлагнах, журамд заасны дагуу хуралдаан зохион байгуулах ажлуудыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аймгийн дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг ил тод мэдээлэхээр тусгасан боловч биелэлтийг бүрэн хангуулаагүй байна.

1.12 Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайланд “Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн мэдээ тайлан гаргах, гэрээний ил тод байдлын цахим санд шинээр байгуулсан гэрээг оруулах” арга хэмжээг хагас, бүтэн жилээр хэрэгжүүлэхээр тусгажээ.


1.13 Дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланд байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж авахаар 6 аж ахуй нэгжтэй байгуулсан гэрээг www.iltodgereee.mn эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд байршуулан олон нийтэд ил тод мэдээлсэн гэж тайлагнасан боловч тус сайтад огт мэдээлээгүй байна.

1.14 Уул уурхайн аж ахуйн нэгж нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах нийт 64 гэрээ байгуулснаас эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд 2023 онд 10, 2025 онд 10 гэрээг мэдээлж, 2024 онд гэрээ мэдээлээгүй байна.

³ Дэд зөвлөлийн хуралдааныг хагас жилд нэг удаа хуралдуулах бөгөөд дэд зөвлөлийн даргын эсвэл зөвлөлийн гишүүдийн олонх, эсвэл оролцогч талуудын аль нэг тал санал болгосноор ээлжит бус хуралдаан зохион байгуулна.

⁴ Дэд зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл гаргах бөгөөд тэмдэглэлийг дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтөлж, дэд зөвлөлийн даргаар гарын үсэг зуруулж албажуулан архивын журмын дагуу бүрдүүлж архивын нэгж болгон хадгална.

Дүрслэл 2. Орон нутагтай хамтран ажиллах гэрээг мэдээллийн санд байршуулсан байдал



Эх сурвалж: *lftodger.ee.mn* (2025 оны мэдээлэл 9 дүгээр сарын байдлаар)

1.15 Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санд гэрээг бүрэн мэдээлэхээр тусгасан боловч 2023-2025 онуудад нийт 44 гэрээг мэдээлээгүй байна.

1.16 Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөл 2023 оны тайлан, 2024 оны төлөвлөгөө, тайланг ОУИТБС-ын Үндэсний зөвлөлд хүргүүлээгүй байна.

Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулах **зөвлөмжийг хүргүүлсэн.**

БҮЛЭГ 2. Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг хийгээгүй, гэрээг загварын дагуу байгуулаагүй байна.

Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүйгээр орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулжээ.

2.1 Аймгийн хэмжээнд 2025 оны 09 дүгээр сарын байдлаар 138 тусгай зөвшөөрлийг давхардсан тоогоор 86 аж ахуй нэгжид олгосон байна.

2.2 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1⁵-д заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгж байгууллагууд үйл ажиллагаа явуулсан эсэхээс үл хамааран орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахаар тусгасан.

2.3 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг 2023 онд 21, 2024 онд 14, 2025 онд 29, нийт 64 тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулжээ.

2.4 Аймгаас бодлогын хэмжээнд тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй 2025 онд нэгдсэн уулзалт зохион байгуулж, гэрээг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулан, өмнөх оноос 2 дахин их буюу 29 гэрээг аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нар хамтран гурвалсан гэрээ байгуулсан байна.

2.5 Аймгийн хэмжээнд 2025 онд 29 гэрээг 58 лиценз эзэмшигчтэй байгуулсан ба 80 лиценз эзэмшигчтэй гэрээг байгуулаагүй байна.

2.6 Нутгийн захиргааны байгууллагууд нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 57.9 хувьтай гэрээ байгуулаагүй шалтгаан, нөхцөл байдал тодорхойгүй байна.

2.7 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2⁶-д орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар заасан байна.

Хүснэгт 2 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээ

№	Сум	Орон нутгийн захиргааны байгууллагатай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний тоо			Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан гэрээний тоо		
		2023 он	2024 он	2025 он	2023 он	2024 он	2025 он
1	Алтай сум	5	5	6	-	-	-
2	Бигэр сум	-	-	3	-	-	-
3	Бугат сум	1	1	2	-	-	-
4	Дэлгэр сум	-	-	-	-	-	-
5	Есөнбулаг сум	2	2	3	-	-	-
6	Жаргалан сум	-	-	-	-	-	-
7	Тайшир сум	5	2	5	-	-	-
8	Тонхил сум	1	-	-	-	-	-
9	Төгрөг сум	1	-	1	-	-	-
10	Халиун сум	-	-	-	-	-	-
11	Хөхморьт сум	1	-	1	-	-	-
12	Цогт сум	1	1	1	-	-	-
13	Цээл сум	1	1	1	-	-	-

⁵ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.

⁶ Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.2-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулна.

14	Чандмань сум	1	1	1	-	-	1
15	Шарга сум	-	-	1	-	-	-
16	Эрдэнэ сум	2	1	4	-	-	-
17	Аймаг						
	Дүн	21	14	29	-	-	1

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.8 Дээрх хүснэгтээс харахад Чандмань сумын 2025 онд байгуулсан 1 гэрээнээс бусад гэрээг байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна.

2.9 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэд олон нийтээр хэлэлцүүлээгүйгээс иргэдийн санал тусгагдахгүй, үр өгөөж хүртэх боломж хангалтгүй байна.

2.10 Цаашид олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан саналыг эрэмбэлж, иргэд олон нийтийн оролцоог хангаж ажиллах шаардлагатай байна.

Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээ байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг хийж, саналыг эрэмбэлэн тусгах **зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.**

Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээний 44.0 хувийг загвар гэрээний дагуу байгуулаагүй байна.

2.11 Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10⁷-т заасны дагуу гэрээний загварыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан байна.

2.12 Сумдын нутгийн захиргааны байгууллагууд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан 64 гэрээний 44.0 хувь буюу 28 гэрээг загварын дагуу байгуулаагүй байна.

Үүнд: Алтай сум 15, Эрдэнэ сум 5, Бугат сум 3, Есөнбулаг сум 2, Хөхморьт сум 2, Төгрөг сум 1 гэрээ байна.

Хүснэгт 3 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээ

Үзүүлэлт	2023 он	2024 он	2025 он	Дүн
Нийт	21	14	29	64
Загварын дагуу	12	6	18	36
Загварын бус	9	8	11	28
Эзлэх хувь /загварын дагуу/	57%	43%	62%	56%
Эзлэх хувь /загварын бус/	43%	57%	37%	44%

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Загварын дагуу байгуулаагүй гэрээ	Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний нэр, мөнгөн дүн, гэрээний эхлэх дуусах хугацаа, Хамтын ажиллагааны хороо болон талуудын хариуцлагын талаарх заалтыг тодорхой тусгаагүй, гэрээний хавсралтыг талууд батлаагүй, тамга тэмдгээр албажуулаагүй.
--	---

Тухайлбал: Есөнбулаг сумын Болдгянтболд ХХК-тай /MV-021169/ 2025 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд 100.0 сая төгрөгөөр санхүүжүүлэх арга хэмжээ тодорхойгүй, Хан Алтай ресурс ХХК-тай 2023-2025 онд байгуулсан нийгмийн

⁷ энэ хуулийн 42.1-д заасан гэрээний загварыг батлах;

хариуцлагын гэрээний хавсралт "Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2 тал харилцан батлаагүй, зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч баталгаажуулсан байна.

2.13 Гэрээний харилцагч талууд хариуцлагын заалтыг тодорхой тусгаагүйгээс гэрээний хэрэгжилт хангагдахгүй байх эрсдэл үүссэн байна.

Гэрээний харилцагч талууд цахим хуудсандаа орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг нээлттэй ил тод мэдээлээгүй байна.

2.14 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 , Засгийн газрын “Гэрээний загвар батлах тухай” 2016 оны 179 дүгээр тогтоолын 5.1 -д зааснаар талууд цахим хуудсандаа гэрээг иргэд, олон нийтэд ил тод мэдээлэх үүрэгтэй байна.

2.15 Аймгийн хэмжээнд 2023-2025 онд байгуулсан 64 гэрээнээс Цогт эрин транс ХХК нь 2023 онд байгуулсан 1 гэрээг өөрийн байгууллагын цахим хуудсанд мэдээлж, бусад аж ахуй нэгжүүд мэдээлээгүй байна.

2.16 Нутгийн захиргааны байгууллагууд 2023-2025 онд байгуулсан гэрээг цахим хуудсандаа огт мэдээлээгүй байна.

2.17 Иргэдэд мэдээлэл авах эрхийг таниулан сурталчлах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургалт зохион байгуулах, оролцоог хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлж байна.

2.18 Гэрээ байгуулагч талууд мэдээллийг мэдээллийн самбар, цахим хуудас, орон нутгийн мэдээллийн хэрэгслээр сурталчлаагүйгээс иргэд олон нийт огт мэдээлэлгүй байна.

Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, гэрээг ил тод нээлттэй мэдээлж байх **зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.**


Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээний харилцагч талууд хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд хариуцлага тооцох хууль эрх зүйн зохицуулалтыг тусгах асуудлыг судалж шийдвэрлүүлэх талаар **Үндэсний аудитын газарт санал хүргүүлээ.**

БҮЛЭГ 3. Харилцагч талууд нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээнд тусгаагүй хандив, тусламж авч зарцуулсан байна.

Гэрээний хэрэгжилт 45.0 хувьтай, талууд гэрээг дүгнээгүй байна.

3.1 Монгол Улсын Засгийн газрын "Гэрээний загвар батлах тухай" 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан загварт тухайн шатны Засаг даргын эрх, үүрэг 6 заалт, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг 9 заалтыг тусгахаар байна.

Дүрслэл 3. Гэрээг дүгнэсэн байдал /тоогоор/



3.2 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээнүүдэд 2 талын эрх үүргийг ерөнхий утгаар тусгасан байна.

3.3 Аймгийн хэмжээнд 2023-2024 онд 35 гэрээ байгуулснаас 27 гэрээг дүгнээгүй байна.

3.4 Нийгмийн хариуцлагын гэрээг талууд дүгнээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ санаачилгагүй ажиллажээ.

3.5 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын 2023 оны 21 гэрээнд тусгасан нийт 82 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 63 арга хэмжээ буюу 76.0 хувь нь хандив, тусламж, дэмжлэг үзүүлэхээр байна.

3.6 Харин 2024 оны 14 гэрээнд нийт 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 62 арга хэмжээ буюу 95.0 хувь нь хандив, тусламж, дэмжлэг үзүүлэхээр байна.

3.7 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын 2025 оны 29 гэрээнд нийт 82 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 68 арга хэмжээ буюу 83.0 хувь нь хандив, тусламж, дэмжлэг үзүүлэхээр байна.

3.8 Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээнд 2023 онд байгуулсан 21 гэрээнд 3,522.0 сая төгрөгийн 77 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 523.4 сая төгрөгийн 42 арга хэмжээг хэрэгжүүлж, 2,599.2 сая төгрөгийн 19 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, Хан Алтай ресурс ХХК-тай холбоотой 399.5 сая төгрөгийн 16 арга хэмжээ хэрэгжсэн эсэх нь тодорхой бус байна.

Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ (2023 он)	- Цээл сумын ЗДТГ, Алтайн-Хүдэр ХХК-тай 2023 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний “халаалт, цэвэр бохир усны дэд бүтэц” бий болгох арга хэмжээнд 2,500.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэх, - Тайшир сумын ЗДТГ, Содгазар ХХК-тай 2023 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний “Тайшир сумд баригдах орон сууц төслийн бохирын асуудалд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээнд 35.0 сая төгрөгийн, мод тарих арга хэмжээнд 5.0 сая төгрөгийн хандив, тусламж өгөх, - Алтай сумын ЗДТГ, БХДБ ХХК-тай 2023 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний 6 арга хэмжээнд 10.0 сая төгрөгийн хандив тусламж өгөх, - Тайшир сумын ЗДТГ, Бакунатур ХХК-тай 2023 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний мод тарих арга хэмжээнд 3.0 сая төгрөгийн хандив, тусламж үзүүлэх, - Аймгийн Засаг дарга, Хан Алтай ресурс ХХК-тай 2023 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний Бэлчээрийн доройтлоос
--	--

	хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд 21.4 сая төгрөг, байгаль хамгаалагч нарт урамшуулал олгоход 10.8 сая төгрөг, мал аж ахуй эрхлэх, ноолуур бэлтгэх, бэлчээр ашиглах зохистой дадлыг хэрэгжүүлэхэд 12.0 сая төгрөг нийт 44.2 сая төгрөгийн арга хэмжээг санхүүжүүлэх арга хэмжээ хэрэгжээгүй.
--	---

3.9 Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах 2024 онд байгуулсан 14 хийгмийн хариуцлагын гэрээнд 2,084.5 сая төгрөгийн 66 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 1,042.8 сая төгрөгийн 41 арга хэмжээг хэрэгжүүлж, 348.0 сая төгрөгийн 5 арга хэмжээг хэрэгжүүлээгүй, Хан Алтай ресурс ХХК-тай байгуулсан гэрээнд тусгасан 693.6 сая төгрөгийн 20 арга хэмжээг хэрэгжсэн эсэх нь тодорхой бус байна.

Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ (2024 он)	- Алтай сумын ЗДТГ, Ар Эм Си трейд ХХК-тай 2024 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд 1500 ширхэг банзны дэмжлэг үзүүлэх, - Аймгийн Засаг дарга, Хан Алтай ресурс ХХК-тай 2024 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд сумын иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулахад 19.5 сая төгрөг, сургуулийн орчны аюулгүй байдлыг сайжруулахад 16.0 сая төгрөг, эмч болон сувилагч нарыг чадавхжуулах сургалт зохион байгуулахад 8.0 сая төгрөг, олон нийтийн соёл амралтын хүрээлэн байгуулах төсөлд 300.0 сая төгрөг нийт 343.5 сая төгрөгийн арга хэмжээ хэрэгжээгүй байна.
---	---

3.10 Есөнбулаг сумын ЗДТГ-аас Хан Алтай ХХК-тай байгуулсан гэрээний дагуу хийсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж ирүүлээгүй.

3.11 Хан Алтай ресурс ХХК-аас ирүүлсэн нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтийн тайланд дурдсан 2023 оны 399.8 сая төгрөгийн 16 арга хэмжээ, 2024 оны 693.7 сая төгрөгийн 20 арга хэмжээ хэрэгжсэн эсэх баримт нотолгоо хангалтгүй байна.

3.12 Хан Алтай ресурс ХХК-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хавсралт 2 Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр"-ийг 2 тал батлаагүй, орон нутгийн аж ахуй нэгж байгууллагаас худалдан авсан бараа, бүтээгдэхүүний өртгийг гэрээний хүрээнд дэмжлэг үзүүлснээр тусгаж, тайлагнасан байна. Тухайлбал: Хан Алтай ресурс ХХК-тай байгуулсан орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан "Орон нутгийн хөгжлийн хөтөлбөр"-ийн 4.2.2 дахь заалт "Оёдол мужааны үйлдвэрлэлийг хөгжүүлэх", 4.2.3 дахь заалт "Орон нутгийн бизнес эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх"-ээр нийт 103.5 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн тайлангаар тус компани нь Говь-Алтай аймгийн иргэн, аж ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулж худалдан авалт хийсэн тухай тайлагнасан байна.

3.13 Аймгийн хэмжээнд 2023-2024 онд хэрэгжсэн нийт 1,556.2 сая төгрөгийн 87 арга хэмжээнээс сумын ОНХС-д 155.0 сая төгрөг, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээнд 457.4 сая төгрөг, бусад арга хэмжээнд 943.8 (байгаль орчныг хамгаалах, хувь хүн хуулийн этгээдэд тусламж, дэмжлэг) сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 4 Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан арга хэмжээний хэрэгжилт (сая төг)

Гэрээний заалт	Он	Гэрээ	Төлөвлөсөн арга хэмжээ		Хэрэгжсэн арга хэмжээ		Хэрэгжээгүй арга хэмжээ		Тодорхойгүй арга хэмжээ	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэд бүтцийг хөгжүүлэх	2023	21	15	2,542.0	3	7.0	12	2,535.0		
Ажлын байр нэмэгдүүлэх	2023		4	2.0	3		1	2.0		
Хандив тусламж	2023		58	978.0	36	516.4	6	62.2	16	399.4
2023 оны дүн		21	77	3,522.0	42	523.4	19	2,599.2	16	399.4

Дэд бүтцийг хөгжүүлэх	2024	14	3		3					
Ажлын байр нэмэгдүүлэх	2024		1		1					
Хандив тусламж өгөх	2024		62	2,084.5	37	1,042.8	5	348.0	20	693.7
2024 оны дүн		14	66	2,084.5	41	1,042.8	5	348.0	20	693.7
Дэд бүтцийг хөгжүүлэх	2025	29	7	80.0	Гэрээний хугацаа дуусаагүй					
Ажлын байр нэмэгдүүлэх	2025		7	20.0	Гэрээний хугацаа дуусаагүй					
Хандив тусламж өгөх	2025		68	2,811.0	Гэрээний хугацаа дуусаагүй					
2025 оны дүн		29	82	2,911.0	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН		64	225	8,517.5	83	1,566.2	24	2,947.2	36	1093.1


3.14 Орон нутагтай хамтран ажиллах 2025 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх арга хэмжээ 17.0 хувийг эзэлж байна.

3.15 Иймд гэрээ байгуулахдаа иргэд олон нийтийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн, сум орон нутагт хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалт, арга хэмжээг санхүүжүүлдэг байх зайлшгүй шаардлагатай байна.

3.16 Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгасан арга хэмжээний санхүүжилтийг сумын ОНХС, сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс болон хувь хүн, хуулийн этгээдийн дансаар дамжуулсан байна. Тухайлбал: Сумын ЗДТГ, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар 2023 онд 24.0 сая төгрөг, 2024 онд 35.0 сая төгрөг, 2025 онд 10 сая төгрөг нийт 69.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4⁸, " 25.7⁹, 60.2.9¹⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна.

3.17 Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээнд 2 тал харилцан тохиролцон хэрэгжүүлэх арга хэмжээний зориулалт, мөнгөн дүн, байршил, хугацаа, хариуцлагын заалт болон бусад мэдээллийг тодорхой тусгаж өгөөгүй байна.

Дүрслэл 4. Мөнгөн хандив, тусламжийг дансанд төвлөрүүлсэн байдал (сая төгрөг)



⁸ Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно",

⁹ "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана",

¹⁰ Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламж"

3.18 Мөн хандив тусламж, дэмжлэгийг хувь хүн, хуулийн этгээд, сумын ЗДТГ, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн нь урсгал зардалд хяналтгүй зарцуулах, гэрээ хэрэгжихгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

3.19 Гэрээний дагуу 2023-2024 онд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ 1,566.2 сая төгрөгөөс 525.7 сая төгрөгийг урсгал зардалд (баяр наадам, тэмцээн уралдаан, шагнал, сургалт, иргэдэд дэмжлэг үзүүлэх, байгаль орчныг хамгаалах, мод тарих, урсгал засварт) зарцуулсан байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт №1-аас үзнэ үү.)*

Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг дүгнэж, Хамтын ажиллагааны хороог байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах **зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.**

Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгаагүй 423.1 сая төгрөгийн, гэрээ байгуулахгүйгээр 346.5 сая төгрөгийн хандив, тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авсан байна.

3.20 Сумдын ЗДТГ нь 2023-2025 онд нийгмийн хариуцлагын гэрээнд тусгаагүй 32 арга хэмжээнд 423.1 сая төгрөгийн хандив, дэмжлэг авснаас аймаг, сумдын 100 жилийн ойд 285.5 сая төгрөг, өвс тэжээлийн дэмжлэгт 39.5 сая төгрөг, боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт 39.4 сая төгрөг, сар шинийн баяр, хурал, зөвлөгөөнд 32.8 сая төгрөгийг, бусад арга хэмжээнд (зам засвар, оюутны сургалтын төлбөр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд) 25.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт №2-оос үзнэ үү)*

3.21 Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгаагүй хандив, тусламж авсан нь Ашигт малтмалын тухай хуулийн 42.5¹¹ дахь заалтыг зөрчсөн байна.

3.22 Сумдын ЗДТГ 2023-2025 онд нийгмийн хариуцлагын гэрээ байгуулахгүйгээр 29 арга хэмжээнд 346.5 сая төгрөгийн хандив, тусламж авснаас аймаг, сумдын 100 жилийн ойд 176.1 сая төгрөг, соёлын төв, засвар үйлчилгээнд 78.0 сая төгрөг, төрийн байгууллага болон иргэдэд 32.9 сая төгрөгийн бараа материал, сумдын ЗДТГ-т урсгал зардалд 32.0 сая төгрөг, баяр тэмдэглэх, тэмцээн уралдаанд 27.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. *(Дэлгэрэнгүйг хавсралт №3-аас үзнэ үү)*

3.23 Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулахгүйгээр хандив, тусламж авсан нь Төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3¹², 25 дугаар зүйлийн 25.2¹³ дахь заалттай нийцэхгүй байна.

Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээнд тусгаагүй, гэрээ байгуулахгүй хандив, тусламж авахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах **зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн.**


¹¹ Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 42.1-д заасан гэрээнд тусгаагүй хандив, тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хориглоно.

¹² Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна

¹³ Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн доор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно

Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд бий болсон 599.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Дүрслэл 5. Хандив тусламжаар өгсөн хөрөнгийн бүртгэл /сая төгрөгөөр/



3.24 Нийгмийн хариуцлагын гэрээний дагуу 2023-2025 онд авсан 1,409.7 сая төгрөгийн хандив, тусламжийн 23.3 хувь буюу 329.7 сая төгрөгийг урсгал зардалд /сумын 100 жилийн ой, шагнал урамшуулал, тэмцээн уралдаан, боловсролын чанар сайжруулах хөтөлбөр/, 34.4 хувь буюу 480.2 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, 42.5 хувь буюу 599.8 сая сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

Нийгмийн хариуцлагын гэрээний дагуу бий болсон 599.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй зөрчлийг арилгах **албан шаардлага хүргүүлсэн..**

БҮЛЭГ 4. Нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтийг ил тод мэдээлээгүй, хяналт тавих Хамтын ажиллагааны хороог байгуулаагүй байна.

Харилцагч талууд гэрээний биелэлтийн тайланг холбогдох газарт хугацаанд нь хүргүүлээгүй, иргэд олон нийтэд нээлттэй ил тод мэдээлээгүй байна.

4.1 Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын 5.2¹⁴, 5.3¹⁵-т талууд гэрээний хэрэгжилтийг хангуулж, биелэлтийн тайланг сумын ИТХ, аймгийн Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх заалтыг хэрэгжүүлэхгүй байна.

Хамтын ажиллагааны хороо байгуулаагүй, нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

4.2 Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулахаар Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын 4 дүгээр бүлэгт тусгасан байна.

4.3 Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд томилох иргэдийн төлөөллийг иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлж, тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлөхөөр тусгасан байна.

4.4 Аймгийн хэмжээнд 2023-2025 онд байгуулсан 64 гэрээнээс Есөнбулаг сумын 1, Чандмань сумын 1 гэрээний хэрэгжилтэд хяналт тавих Хамтын ажиллагааны хороог байгуулсан байна.

4.5 Есөнбулаг сум, Хан Алтай ресурс ХХК /MV-021537/-тай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороог аймгийн Засаг даргын 2025 оны А/225 дугаар захирамжаар байгуулсан байна. Хамтын ажиллагааны хорооны бүрэлдэхүүнд иргэдийн төлөөлөл томилоогүй, талуудын оролцоог тэгш хангаагүй байна.

4.6 Чандмань сум, Сэкер ресурс монголиа ХХК-тай 2025 онд байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороог сумын Засаг даргын 2025 оны А/31 дүгээр захирамжаар байгуулжээ.

4.7 Бусад сумдын нийгмийн хариуцлагын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих Хамтын ажиллагааны хороо байгуулаагүйгээс хяналт тавих үйл явц орхигдсон байна.

Есөнбулаг сум, Хан Алтай ресурс ХХК /MV-021537/-тай байгуулсан гэрээний Хамтын ажиллагааны хороонд иргэдийн төлөөллийг томилох зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн.

4.8 Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолын 14¹⁶-т Мэргэжлийн хяналтын Ерөнхий газарт ашигт малтмалын тухай хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, энэ талаар Үндэсний зөвлөлд тайлагнаж, ил тод мэдээлэх үүргийг даалгасан байна.

4.9 Гэвч Мэргэжлийн хяналтын газар татан буугдсантай холбоотой дээрх хяналтын чиг үүрэг хэрэгжээгүй байна.

¹⁴ дараах арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай.

¹⁵ дараах арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай.

¹⁶ дараах арга хэмжээ авч ажиллахыг Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга Р.Содхүүд даалгасугай.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн хэмжээнд 2025 оны 09 дүгээр сарын байдлаар хайгуулын болон ашиглалтын 138 тусгай зөвшөөрлийг 86 аж ахуй нэгж эзэмшиж байна.
- Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг 2023 онд байгуулсан боловч бүрэлдэхүүнд компанийн төлөөллийг томилоогүй, сумдад дэд зөвлөлийг байгуулаагүйгээс хандив, тусламж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, хяналт тавих чиг үүргийн хэрэгжилт хангагдаагүй байна.
- Аймгийн хэмжээнд хүчинтэй 138 лиценз эзэмшигчээс 2025 онд 58 лиценз эзэмшигчтэй 29 нийгмийн хариуцлагын гэрээг байгуулсан нь нийт лиценз эзэмшигчийн 42.0 хувийг эзэлж байна.
- Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг иргэд олон нийтээр хэлэлцүүлээгүйгээс иргэдийн санал тусгагдахгүй, үр өгөөж хүртэх боломж хангалтгүй байна.
- Аймгийн хэмжээнд 2023-2025 онд гэрээний дагуу 1,566.2 сая төгрөгийн, гэрээнээс илүү 423.1 сая төгрөгийн, гэрээ байгуулахгүйгээр 346.5 сая төгрөгийн, нийт 2,335.8 сая төгрөгийн хандив, тусламж дэмжлэгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс авсан байна.
- Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах 2023 онд байгуулсан 21, 2024 онд байгуулсан 14 нийгмийн хариуцлагын гэрээнд нийт 5,606.5 сая төгрөгийн 143 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.
- Үүнээс 1,566.2 сая төгрөгийн 83 арга хэмжээг хэрэгжүүлж, 3,247.2 сая төгрөгийн 24 арга хэмжээ хэрэгжээгүй, 1 аж ахуй нэгжтэй холбоотой 1,093.1 сая төгрөгийн 36 арга хэмжээг хэрэгжсэн эсэхийг нотлох боломжгүй байна. Нийт 525.7 сая төгрөгийг (баяр наадам, тэмцээн уралдаан, шагнал, иргэдэд дэмжлэг, тусламж, мод тарих) урсгал зардлын шинжтэй арга хэмжээнүүдэд зарцуулсан байна.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдээс гэрээнд тусгаагүй 423.1 сая төгрөгийн хандив, тусламж авч аймаг, сумдын 100 жилийн ойд 285.5 сая төгрөг, өвс тэжээлийн дэмжлэгт 39.5 сая төгрөг, боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрт 39.4 сая төгрөг, сар шинийн баяр, хурал, зөвлөгөөнд 32.8 сая төгрөгийг, бусад арга хэмжээнд (зам засвар, оюутны сургалтын төлбөр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд) 25.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Гэрээ байгуулахгүйгээр тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдээс 346.5 сая төгрөгийн хандив, тусламж авч, аймаг, сумдын 100 жилийн ойд 176.1 сая төгрөг, соёлын төв, засвар үйлчилгээнд 78.0 сая төгрөг, төрийн байгууллага болон иргэдэд 32.9 сая төгрөгийн бараа материал, сумдын ЗДТГ-т урсгал зардалд 32.0 сая төгрөг, баяр наадам, тэмцээн уралдаанд 27.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.
- Нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд олгосон хандив, тусламжийг сумын ОНХС, сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс болон хувь хүн, хуулийн этгээдийн дансаар дамжуулан зарцуулсан байна.
- Харилцагч талууд эрх, үүргээ хэрэгжүүлээгүй, гэрээг дүгнээгүй, гэрээний хэрэгжилтийг хангуулах Хамтын ажиллагааны хороог байгуулаагүйгээс шалтгаалан 2,559.5 сая төгрөгийн 5 гэрээний биелэлт хангагдаагүй байна.

- Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг хэрэгжүүлээгүй байхад талууд хариуцлагын арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Гэрээний дагуу бий болсон 599.8 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байна.
- Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээний 44.0 хувийг холбогдох журамд заасан загварын дагуу боловсруулаагүй, хэрэгжүүлэх арга хэмжээ, талуудын эрх үүргийг тодорхой тусгаагүй, хавсралтыг баталж, тамга тэмдгээр албажуулаагүй, иргэд олон нийтэд нээлттэй ил тод мэдээлээгүй байна.

Аудитын дүгнэлтэд үндэслэн аймаг, сумдын Засаг дарга, аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд 685.7 сая төгрөгийн 52 зөвлөмж, Эрүүл мэндийн газар, сумдын Засаг дарга, Тайшир сумын Эрүүл мэндийн төвийн дарга нарт 754.1 сая төгрөгийн 16 заалт албан шаардлага, 4 сумдын Засаг дарга нарт хариуцуулан 19.0 сая төгрөгийн 4 төлбөрийн актыг тогтоож, Үндэсний аудитын газарт 1 саналыг уламжилсан.

ШИЙДВЭР

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрийг хүргүүлж байна.

ЗӨВЛӨМЖ

Аймаг, сумдын Засаг дарга нарт:

- Хан Алтай ресурс ХХК-тай байгуулсан гэрээний хамтын ажиллагааны хороонд иргэдийн төлөөлөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөл, захиргааны төлөөллийн тоог тэгш байх зарчмыг баримтлан томилох.
- Орон нутагтай хамтран ажиллах нийгмийн хариуцлагын гэрээг байгуулахдаа олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, гэрээг цахим хуудас болон эрдэс баялгийн мэдээллийн санд нөхөн байршуулах.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээнд тусгагдаагүй хандив, тусламж авахгүй байх.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулахгүйгээр хандив, тусламж авч зарцуулахгүй байх.
- Нийгмийн хариуцлагын гэрээг дүгнэх хамтын ажиллагааны хороог байгуулж гэрээний хэрэгжилтэд хяналт тавин, олон нийтэд мэдээлэх.

Сумдын Засаг дарга нарт:

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийг байгуулж, ажиллах.

Аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд

- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг тайлагнаж ажиллах.

АЛБАН ШААРДЛАГА

Цогт, Эрдэнэ, Есөнбулаг сумдын Засаг дарга нарт

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн зөвшөөрөлгүйгээр хандив, тусламж авч байгаа зөрчлийг арилгах.

Бугат, Төгрөг, Цогт, Чандмань, Эрдэнэ сумдын Засаг дарга нарт

- Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандивын зарцуулалтад хяналт хэрэгжүүлэн хууль тогтоомжид заасны дагуу холбогдох арга хэмжээг авах.

Дэлгэр, Тайшир, Төгрөг, Чандмань, Есөнбулаг сумдын Засаг дарга, Тайшир сумын Эрүүл мэндийн төв, Эрүүл мэндийн газрын дарга нарт

- Хандив тусламжаар ирсэн хөрөнгийг анхан шатны баримт материалыг үндэслэн данс бүртгэлд тусгах.

ТӨЛБӨРИЙН АКТ

Алтай, Дэлгэр, Тайшир, Хөхморьт сумдын Засаг даргын тамгын газрын дарга нарт

- Нийгмийн хариуцлагын гэрээний дагуу бий болсон хандив, тусламжийн орлогыг сумын ОНХС-гийн дансанд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны дотор төвлөрүүлэх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Жинст баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82093
Утас: 7048-4004, Факс: 7048-3360

2025. 11.08 № 2/1507

танай _____ -ны № _____ -т

**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

"Уул уурхайн аж ахуйн нэгжүүд, төрийн захиргааны байгууллагуудтай байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар сумууд орон нутагтай хамтран ажиллах гэрээнд тусгагдаагүй болон гэрээ байгуулаагүй хандив тусламж тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжээс авч зарцуулсан зөрчил илэрсэн байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах албан шаардлагыг зөрчил гаргасан сумдад хүргүүлэхийг хүсье.

ОРЛОГЧ

М.АЛТАНГЭРЭЛ

D/ajil/udirdlaga ZDO A-5

2025.11.08

САНАЛД ӨГСӨН ХАРИУ ТАЙЛБАР

№	Санал	Хариу тайлбар
1	Уул уурхайн аж ахуй нэгжээс гэрээ байгуулаагүй болон гэрээнд тусгагдаагүй хандив, тусламж авсан зөрчлийг тухайн сумдад шийдвэр өгөх	Саналыг харгалзан үзээд зөрчил гаргасан тухайн сумдад зөвлөмжөөр хүргүүллээ.

Хавсралт 1. Урсгал зардлын шинжтэй арга хэмжээний жагсаалт

№	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Мөнгөн дүн (төгрөг)
1	Баяр наадам	3,500,000.00
2	Машины засвар	26,000,000.00
3	Бэлэн мөнгөөр өгсөн хандив /ОНХС-д/	30,000,000.00
4	Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн баримтат кино	5,000,000.00
5	Сургалт, хэлэлцүүлэг, шагнал	11,580,000.00
6	Үрсэлгээ, мод тарих	16,400,000.00
7	Сумын 100 жилийн ойд	85,000,000.00
8	Иргэдэд нүүрс тараасан	34,650,000.00
9	Сумын 100 жилийн ойд	15,000,000.00
10	Биеийн тамирын багшийн урамшуулал	1,500,000.00
11	Багийн төвийн засвар	3,000,000.00
12	Бага оврын шугам, худгийн ажилд дэмжлэг, засвар	6,000,000.00
13	Соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээ	27,500,000.00
14	Хан Алтай оюутны тэтгэлэг	28,500,000.00
15	ЕБ сумын иргэдийг ЭМ-ийн үзлэгт хамруулах	6,400,000.00
16	Малчин өрхүүдэд өвлийн бэлтгэл ажилд тусламж үзүүлэх	16,480,000.00
17	Зохиомол хээлтүүлгийн гэрээ	26,000,000.00
18	Тэрбум мод, 108 сая мод хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	17,500,000.00
19	Идэвхитэн байгаль хамгаалагчид дуран олгох	1,500,000.00
20	Өвлийн улиралд зэрлэг амьтанд өвс тавьж өгөх	1,400,000.00
21	Орон нутгийн түүх соёлын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх	30,000,000.00
22	Хан Алтай оюутны тэтгэлэг	49,000,000.00
23	Хоршоо байгуулах чадавхижуулах	6,500,000.00
24	Малчин өрхүүдэд өвлийн бэлтгэл ажилд тусламж үзүүлэх	18,480,000.00
25	Малын ЭМ, арчилгаа маллагаанд орчин үеийн арга технологийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	29,940,000.00
26	Тэрбум мод, 108 сая мод хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх	24,500,000.00
27	Зэрлэг амьтны ажиглалт, тооллого хийх	3,000,000.00
28	Өвлийн улиралд зэрлэг амьтанд өвс тавьж өгөх	1,400,000.00
	НИЙТ ДҮН	525,730,000.00

Хавсралт 2. Нийгмийн хариуцлагын гэрээнд тусгаагүй хандив, тусламжийн жагсаалт

№	1. Ашиг малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл			Гэрээнд тусгаагүй хандив, тусламж	
	Тусгай зөвшөөрлийн дугаар	Сум	Эзэмшигчийн нэр	Он	Мөнгөн дүн (төгрөг)
1	MV-020782	Төгрөг	Цэрдийн тал	2023	20,000,000.00
2	MV-020595	Төгрөг	Хүннү алтай минералс	2023	5,500,000.00
3	MV-020608	Төгрөг	Хүннү алтай минералс	2023	10,000,000.00
4	MV-020609	Төгрөг	Хүннү алтай минералс	2023	1,000,000.00
5	MV-022682	Төгрөг	Хүннү алтай минералс	2023	2,000,000.00
6	XV-020515	Есөнбулаг, Тайшир	Рагнарок инвестмент	2023	20,000,000.00
7	XV-020515	Есөнбулаг, Тайшир	Рагнарок инвестмент	2024	14,145,000.00
8	XV-020515	Есөнбулаг, Тайшир	Рагнарок инвестмент	2025	23,600,000.00
9	XV-020515	Есөнбулаг, Тайшир	Рагнарок инвестмент	2025	1,000,000.00
10	XV-020515	Есөнбулаг, Тайшир	Рагнарок инвестмент	2024	1,755,000.00
11	XV-018305	Хөхморьт, Дарви	Боролзой	2023	20,000,000.00
12	XV-018305	Хөхморьт, Дарви	Боролзой	2023	7,000,000.00
13	MV-013527	Цээл	Алтайнхүдэр	2025	4,770,000.00
14	MV-013527	Цээл	Алтайнхүдэр	2023	100,000,000.00
15	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2025	10,000,000.00
16	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2025	29,400,000.00
17	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2025	10,000,000.00
18	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2025	2,959,908.00
19	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2024	570,000.00
20	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2024	2,000,000.00
21	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2024	500,000.00
22	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2024	4,000,000.00
23	MV-000905	Чандмань	Сэкер ресурсус монголиа	2024	10,000,000.00
24	XV-017883	Тайшир	Бакунатур	2024	10,000,000.00
25	MV-017621	Тайшир	Содгазар	2024	60,000,000.00
26	MV-017689	Тайшир	Цэнгазар	2024	998,800.00
27				2024	40,000,000.00
28				2024	1,606,500.00
29				2025	5,000,000.00
30				2025	2,000,000.00
31				2025	3,000,000.00
32				2025	360,000.00
НИЙТ					423,165,208.00

Хавсралт 3. Нийгмийн хариуцлагын гэрээ байгуулаагүй өгсөн хандив, тусламжийн жагсаалт

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Сум	Эзэмшигчийн нэр	Он	Мөнгөн дүн (төгрөг)
1	XV-021766	Шарга	Ланд-Оре	2024	10,000,000.00
2	XV-017949	Дэлгэр	Фокстрат интернэшнл	2025	5,000,000.00
3	XV-018002	Дэлгэр	Фокстрат интернэшнл	2024	2,500,000.00
4	XV-018791	Дэлгэр	Эй Би Пи Девелопмент	2025	5,000,000.00
5	XV-018795	Дэлгэр	Эй Би Пи Девелопмент	2024	2,500,000.00
6	MV-017121	Дэлгэр	Мандал-Алтай групп	2025	13,574,000.00
7	MV-021975	Дэлгэр	Мандал-Алтай групп		
8	MV-022813	Дэлгэр	Мандал-Алтай групп		1,636,000.00
9	XV-015266	Дэлгэр	Мандал-Алтай групп		
10	XV-016040	Дэлгэр	Глобалбалыш	2023	-
11	XV-016041	Дэлгэр	Глобалбалыш	2024	-
12	XV-016041	Дэлгэр	Глобалбалыш	2023	-
13	XV-020396	Тонхил, Төгрөг	Ресурс партнерс групп	2025	14,000,000.00
14	MV-017580	Тонхил	Юниверсалминерал эксплорейшн	2023	350,000.00
15	MV-021712	Тонхил	Юниверсалминерал эксплорейшн	2023	10,000,000.00
16	XV-015559	Тонхил	Юниверсалминерал эксплорейшн	2023	3,500,000.00
17	MY-021076,	Бигэр	Маркополо	2023	6,500,000.00
18	MY-021243 MY022137	Бигэр, Есөнбулаг	Маркополо	2024	100,000,000.00
19		Бигэр	Маркополо	2025	26,383,390.00
20	XV-017951	Цогт	Ханхэнтийн хүдэр	2023	2,000,000.00
21	XV-017951	Цогт	Ханхэнтийн хүдэр	2023	1,000,000.00
22	XV-017795	Бигэр	Номин эрдэнийн өргөө	2023	2,000,000.00
23	XV-017716	Бигэр	Эн Си Жи Ти	2024	43,000,000.00
24	XV-020820	Бигэр	ЦВД	2023	5,000,000.00
25	XV-020820	Бигэр	ЦВД	2024	6,000,000.00
26	XV-022298	Эрдэнэ	Ланд-Оре	2025	10,000,000.00
27	XV-018398	Эрдэнэ	Ланд-Оре		
28	XV-021215	Эрдэнэ	Ланд-Оре		
29	XV-018305	Хөхморьт, Дарви	Боролзой	2024	6,100,000.00
30	XV-018305	Хөхморьт, Дарви	Боролзой	2024	500,000.00
31	XV-018305	Хөхморьт, Дарви	Боролзой	2025	5,000,000.00
32	XV-022374	Тайшир	Ланд-Оре	2025	5,000,000.00
33	MV-017077	Тайшир	Тайширын хүдэр	2023	60,000,000.00
дүн					346,543,390.00